



**АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2026 оны 4-р сарын 28

Дугаар 26/001

Улаанбаатар хот

Континентал зочид буудал, 2 давхарт байрлах хурлын тэнхимд 10:00 цагаас хуралдав.

Хуралд оролцсон:

ХЭЭХурлын дарга: Г.Хатанболд

ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч: П.Дэлгэрмаа, В.Болорчимэг, З.Төрболд, Г.Гантуяа, О.Мөнхзул

Гүйцэтгэх захирал: Ч.Мөнхжаргал

Хараат бус аудитор: М.Энхжаргал

Бизнес хариуцсан захирал: Д.Жигжид

Техникийн үйл ажиллагааны хэлтсийн менежер: Ч.Гансүлд

Хурлын тооллогын комисс: Х.Уянга, С.Нандинзул, М.Пүрэвжав

Хурал зохион байгуулах комисс: Д.Жигжид, Б.Өнөрбадрах, М.Пүрэвжав, Г.Янжинлхам

Хэлэлцсэн нь:

1. Компанийн 2025 оны бизнесийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;
2. Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
3. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
4. Компанийн 2025 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах;
5. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах;
6. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулж, сонгох;
7. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсвийг батлах.

Хурлын ирц:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс 2026 оны 4 дүгээр сарын 02-ны өдрөөр тасалбар болгон гаргасан хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаанд багтсан нийт 17,897,622.00 ширхэг хувьцаа эзэмшиж буй хувьцаа эзэмшигч буюу 51.94 хувь болсон тул КтХ-ийн 69 дүгээр зүйл 69.1 дэх хэсэгт заасны дагуу хурлын ирц бүрдэж, хурал хүчин төгөлдөрт тооцогдов.

Айтүүлс ХК-ийн ХЭЭХ-ын Тооллогын комиссын дарга Х.Уянга хурлын ирцийг танилцуулж хурлыг хүчин төгөлдөр эхэлж байгааг мэдэгдсэнээр хурал эхлэв.

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2025 оны бизнесийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;
2. Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
3. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
4. Компанийн 2025 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах;
5. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах;
6. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулж, сонгох;
7. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсвийг батлах.

Хэлэлцсэн нь:

1. Айтүүлс ХК-ийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хавсралтаар батлах.
2. Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны зардал болон гишүүдийн цалин урамшууллын төсвийг 66,100,000 /жаран зургаан сая нэг зуун мянга/ төгрөгөөр батлах.
3. Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгох. Үүнд:

Ердийн гишүүд:

1. А.Баттамир
2. П.Дэлгэрмаа
3. Г.Хатанболд
4. В.Болорчимэг
5. Ч.Мөнхжаргал
6. З.Төрболд

Хараат бус гишүүд:

1. Г.Гантуяа
2. О.Мөнхзул
3. Б.Жавхланбаяр

Санал хураалтын дүн:

1. Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлахад санал өгсөн Хувьцаа эзэмшигчдийн 17,897,517 ширхэг хувьцааны санал буюу 99.99 хувийн саналаар зөвшөөрснийг тогтоосугай.
2. Компанийн ТУЗ-ийн 2026 оны үйл ажиллагааны төсвийг батлах тухай санал өгсөн Хувьцаа эзэмшигчдийн 17,897,517.00 ширхэг хувьцааны санал буюу 99.99 хувийн саналаар зөвшөөрснийг тогтоосугай.

3. ТУЗ-ийн гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгосугай.

3.1. Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчдэд кумулятив аргаар өгсөн санал

3.1.1. Нэр дэвшигч А.Баттамирт нийт санал өгсөн эрх 17,952,014

3.1.2. Нэр дэвшигч П.Дэлгэрмаад нийт санал өгсөн эрх 17,854,147

3.1.3. Нэр дэвшигч Г.Хатанболдод нийт санал өгсөн эрх 17,851,114

3.1.4. Нэр дэвшигч В.Болорчимэгт нийт санал өгсөн эрх 17,855,575

3.1.5. Нэр дэвшигч Ч.Мөнхжаргалд нийт санал өгсөн эрх 18,004,138

3.1.6. Нэр дэвшигч З.Төрболдод нийт санал өгсөн эрх 17,851,087

3.2. Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдэд кумулятив аргаар өгсөн санал

3.2.1. Нэр дэвшигч Г.Гантуяад нийт санал өгсөн эрх 17,851,117

3.2.2. Нэр дэвшигч О.Мөнхзулд нийт санал өгсөн эрх 17,851,087

3.2.3. Нэр дэвшигч Б.Жавхланбаярт нийт санал өгсөн эрх 17,977,269

Шийдвэрлэсэн нь:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлав.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төсвийг 66,100,000 /жаран зургаан сая нэг зуун мянга/ төгрөгөөр батлав.

3. ТУЗ-ийн гишүүдээр дараах нэр бүхий 9 гишүүдийг сонгов.

Ердийн гишүүнд: А.Баттамир, П.Дэлгэрмаа, Г.Хатанболд, В.Болорчимэг, Ч.Мөнхжаргал, З.Төрболд

Хараат бус гишүүнд: Г.Гантуяа, О.Мөнхзул, Б.Жавхланбаяр

Тэмдэглэлтэй танилцсан: Г.Хатанболд /ХЭЭХурлын дарга/

Тэмдэглэл хөтөлсөн: Янжинлхам /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/